



**НИЙСЛЭЛИЙН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 1124

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө, эд аж ахуйн 2022 оны жилийн эцсийн тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72, 73, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үндсэн хөрөнгө, эд аж ахуйн хадгалалт, хамгаалалт түүнд тавигдах хяналт шалгалтын ажлын хүрээнд 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Комиссын ахлагч:

С.Отгонбаатар
Хуулийн зөвлөх

Гишүүд:

М.Мөнхдулам
Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа
хариуцсан мэргэжилтэн
Б.Зоригт
Төсөл, хөрөнгө оруулалтын эдийн засагч

2. Үндсэн хөрөнгө эд аж ахуйн тооллогыг үнэн зөв гүйцэтгэн бүртгэж, тайлан мэдээг 2022 оны 12 дугаар сарын 21-ний дотор удирдлагад танилцуулж ажиллахыг Тооллогын комисс (С.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН